

БАТЛАВ
МОНГОЛЫН ӨРХИЙН АНАГААХ УХААНЫ
МЭРГЭЖИЛТНҮҮДИЙН ХОЛБООНЫ
ЕРӨНХИЙЛӨГЧ



Ж.АМАРСАНАА

НИЙТЛЭГ ШААРДЛАГА

Мэргэшлийн зэрэг горилогчид тавигдах шаардлагын санал

“Ахлах” зэрэг горилогчийн нийтлэг шаардлага

№	Нийтлэг шаардлага	Баримтжуулалт
1	Мэргэшлийн зэрэг горилж буй чиглэлээр мэргэжил эзэмшсэн байх,	Диплом эсхүл үндсэн мэргэшлийн үнэмлэх
2	Сум, тосгон, өрхийн эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэгт мэргэжлээрээ эсхүл үндсэн мэргэжлээр 6-аас доошгүй жил тасралтгүй ажилласан байх,	Нийгмийн даатгалын лавлагаа
3	Ажиллаж буй байгууллагаас тухайн мэргэжил, үндсэн мэргэшлийн чиглэлээр зэрэг горилохыг дэмжсэн байх,	Байгууллагын албан бичиг
4	Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх хүчин төгөлдөр зөвшөөрөлтэй байх,	Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хуулбар
5	Жил тутамд тухайн мэргэжлийн холбооноос зохион байгуулсан багц цагийн сургалтад хамрагдаж багц цаг бүрдүүлсэн байх,	ЭМХТ-д баталгаажуулсан линк, гэрчилгээний хуулбар
6	Тухайн мэргэжил, үндсэн мэргэжлээр ажилласан сүүлийн 3 жилд ёс зүйн болон мэргэжлийн алдаа гаргаагүй байх,	Ёс зүйг хорооны тодорхойлолт

“Тэргүүлэх” зэрэг горилогчийн нийтлэг шаардлага

ДД	Нийтлэг шаардлага	Баримтжуулалт
1	Мэргэшлийн зэрэг горилж буй чиглэлээр мэргэжил эзэмшсэн байх	Диплом эсхүл үндсэн мэргэшлийн үнэмлэх
2	Сум, тосгон, өрхийн эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэгт мэргэжил эсхүл үндсэн мэргэжлээр 10-аас доошгүй жил тасралтгүй ажилласан байх	Нийгмийн даатгалын лавлагаа
3	Ажиллаж буй байгууллагаас тухайн мэргэжил, үндсэн мэргэшлийн чиглэлээр зэрэг горилохыг дэмжсэн байх	Байгууллагын албан бичиг
4	Орон нутагт ажиллаж буй эмнэлгийн мэргэжилтний тухайд харьяалах Эрүүл мэндийн газраас тухайн мэргэжил, мэргэшлийн чиглэлээр зэрэг горилохыг дэмжсэн байх	ЭМГ-ын албан бичиг
5	Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх хүчин төгөлдөр зөвшөөрөлтэй байх	Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хуулбар

6	Ажиллаж буй мэргэжил, мэргэшлийн чиглэлээр байгууллага болон бүс, орон нутгийн хэмжээнд төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон тасралтгүй сургалт жил тутам зохион байгуулах эсхүл оролцох, үр дүнд хүрсэн байх	Сургалтын батлагдсан удирдамж, хөтөлбөр, тайлан, оролцогчдын баримт
7	Жил тутамд биелүүлсэн багц цаг сургалтын 2/3-оос доошгүй нь тухайн мэргэжил, мэргэшлийн чиглэлээр байх	ЭМХТ-д баталгаажуулсан линк, гэрчилгээний хуулбар
8	Тухайн мэргэжил, үндсэн мэргэшлээр ажилласан сүүлийн 3 жилд ёс зүйн болон мэргэжлийн алдаа гаргаагүй байх	Ёс зүйн хорооны тодорхойлолт

“Зөвлөх” зэрэг горилогчийн нийтлэг шаардлага

ДД	Нийтлэг шаардлага	Баримтжуулалт
1	Мэргэшлийн зэрэг горилогч буй чиглэлээр мэргэжил эзэмшсэн байх	Диплом эсхүл үндсэн мэргэшлийн үнэмлэх
2	Тухайн мэргэшил, үндсэн мэргэжлээр их эмч, 25-оос доошгүй жил, бага эмч, сувилагч 20-с доошгүй жил ажилласан байх	Нийгмийн даатгалын лавлагаа
3	Ажиллаж буй байгууллагаас тухайн мэргэжил, үндсэн мэргэшлийн чиглэлээр зэрэг горилогчийг дэмжсэн байх	Байгууллагын албан бичиг
4	Орон нутагт ажиллаж буй эмнэлгийн мэргэжилтний тухайд харьяалах Эрүүл мэндийн газраас тухайн мэргэжил, мэргэшлийн чиглэлээр зэрэг горилогчийг дэмжсэн байх	ЭМГ-ын албан бичиг
5	Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх хүчин төгөлдөр зөвшөөрөлтэй байх	Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хуулбар
6	Ажиллаж буй мэргэжил, мэргэшлийн чиглэлээр байгууллага болон бүс, орон нутгийн хэмжээнд төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон тасралтгүй сургалт жил тутам зохион байгуулах эсхүл оролцох, үр дүнд хүрсэн байх	Сургалтын батлагдсан удирдамж, хөтөлбөр, тайлан, оролцогчдын баримт
7	Жил тутамд биелүүлсэн багц цагийн сургалтын 2/3-оос доошгүй нь тухайн мэргэжил, мэргэшлийн чиглэлээр байх	ЭМХТ-д баталгаажуулсан линк, гэрчилгээний хуулбар
8	Тухайн мэргэжил, үндсэн мэргэшлээр ажилласан сүүлийн 5 жилд ёс зүйн болон мэргэжлийн алдаа гаргаагүй байх	Ёс зүйг хорооны тодорхойлолт
9	Салбарын хөгжил, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн асуудалд хувь нэмэр оруулсан байх	Тухайн шалгуураар хийгдсэн үйл ажиллагааны баримт нотолгоо

ТУСГАЙ ШАЛГУУР

ӨРХИЙН АНАГААХ СУДЛАЛ

АХЛАХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

ДД	Тусгай шаардлага	Баримтжуулалт
1	Мэргэжлийн чиглэлийн багц цагийн богино хугацааны сургалтад хамрагдаж жилд багадаа 3 багц цагийг биелүүлсэн байх	ЭМХТ-д баталгаажуулсан линк, гэрчилгээний хуулбар
2	Өрхийн эмч нь ажилласан хугацаандаа өөрөө болон бусадтай хамтран 2-оос доошгүй өгүүлэл, илтгэл эрдэм шинжилгээ, судалгааны ажил хэлэлцүүлэн нийтлүүлсэн байх	Мэргэжлийн сэтгүүлд илтгэлийн хураангуйг нийтлүүлсэн баримт
3	Өрхийн эмч нь ажилласан жилдээ 3-аас доошгүй эмнэлгийн мэргэжилтэнг мэргэшүүлэх сургалтаар дагалдуулан сургаж, дадлагажуулсан байх,	Сургах, дадлагажигч эмчийн гэрчилгээ болон дадлагажсан тайлан
5	Өрхийн эмчийн ажиллах хугацааны сүүлийн 3 жилийн үндсэн ажлын үзүүлэлт 1. Хүн амын тоо 2. Нийт үзлэг 3. Нийт үзлэгт эзлэх гэрийн эргэлт 30% байх 4. УСҮ хувь 10%-иас дээш байх 5. Хяналтын хувь 50%-иас дээш байх 6. Дархлаажуулалтын хамралтын хувь 7. Жирэмсний эрт хяналтын хувь 90%-иас дээш 9. Эхийн эндэгдэл 10. 0-5 насны хүүхдийн хяналтын хувь, эндэгдэл 11. Халдварт бус өвчний хяналтын хувь, - Зүрх судасны өвчний хяналт - Артерийн гипертензи өвчний хяналт - Чихрийн шижин өвчний эрт илрүүлсэн байдал - Хорт хавдар өвчнийг эрт илрүүлсэн байдал - Хоол боловсруулах өвчний хяналт 12. Нийт нас баралтын хувь	Өрхийн эрүүл мэндийн төв дээр хэрэглэж буй программаас татаж авна.
6	Иргэдийн сэтгэл ханамжийн судалгааны дүн	Зөвхөн өөрт өгсөн иргэдийн Сэтгэл ханамжийн судалгааны тайлан, Байгууллагын даргаар баталгаажуулсан байх

ТЭРГҮҮЛЭХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд

ДД	Тусгай шаардлага	Баримтжуулалт
1	Өрхийн эмч нь ахлах зэрэг хамгаалснаас хойш мэргэшил дээшлүүлэх, ур чадвар, удирдахуйн арга барилыг дээшлүүлэх сургалтад хамрагдсан байх,	Сургалтад хамрагдсан гэрчилгээ
2	Мэргэжлийн чиглэлийн багц цагийн богино хугацааны сургалтад хамрагдаж багадаа жилд 3 багц цагийг энэ сургалтаас биелүүлсэн байх	ЭМХТ-д баталгаажуулсан линк, гэрчилгээний хуулбар
3	Өрхийн эмч нь ахлах зэрэг хамгаалснаас хойш нэгдүгээр зохиогчоор болон бусадтай мэргэжилтэнтэй хамтран 3-аас доошгүй өгүүлэл, илтгэл эрдэм шинжилгээ, судалгааны ажил хэлэлцүүлэн нийтлүүлсэн байх	Мэргэжлийн сэтгүүлд илтгэлийн хураангуйг нийтлүүлсэн баримт
4	Өрхийн эмч нь ахлах зэрэг хамгаалснаас хойш 5-аас доошгүй эмнэлгийн мэргэжилтэнг мэргэшүүлэх сургалтаар дадлагажуулсан байх эсвэл сургагч багшаар ажилласан байх	Сургах, дадлагажуулах удирдамж эсвэл журам, дадлагажигч эмчийн гэрчилгээ болон тайлан хамгаалалт
6	Өрхийн эмч нь ахлах зэрэг хамгаалснаас хойш тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах сайн туршлагыг нэвтрүүлсэн байх	Сайн туршлагын батламж, эсвэл дээд байгууллагын Чанарын алба баталгаажуулсан байх
7	Өрхийн эмчийн ажиллах хугацааны сүүлийн 5 жилийн үндсэн ажлын үзүүлэлт 1. Хүн амын тоо 2. Нийт үзлэг 3. Нийт үзлэгт эзлэх гэрийн эргэлт 30% байх 4. УСҮ хувь 10%-иас дээш байх 5. Хяналтын хувь 50%-иас дээш байх 6. Дархлаажуулалтын хамралтын хувь 7. Жирэмсний эрт хяналтын хувь 90%-иас дээш 9. Эхийн эндэгдэл 10. 0-5 насны хүүхдийн хяналтын хувь, эндэгдэл 11. Халдварт бус өвчний хяналтын хувь, - Зүрх судасны өвчний хяналт - Артерийн гипертензи өвчний хяналт - Чихрийн шижин өвчний эрт илрүүлсэн байдал - Хорт хавдар өвчнийг эрт илрүүлсэн байдал - Хоол боловсруулах өвчний хяналт 12. Нийт нас баралтын хувь	Тухайн байгууллагын хэрэглэж буй программаас татаж авна.
8	Иргэдийн сэтгэл ханамжийн судалгааны эерэг үзүүлэлт 70%-иас дээш байх	Зөвхөн өөрт өгсөн иргэдийн Сэтгэл ханамжийн судалгааны тайлан, Байгууллагын даргаар баталгаажуулсан байх

ЗӨВЛӨХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

ДД	Тусгай шаардлага	Баримтжуулалт
1	Өрхийн эмч нь аль нэг ерөнхий мэргэжил болон аль нэг үндсэн мэргэжил /хүүхэд, дотор, эх барих, мэс засал бусад/ эзэмшсэн байх	Мэргэшсэн үнэмлэхийн хувийг нотариатаар баталгаажуулсан байх
2	Магистр эсвэл докторын эрдмийн зэрэг хамгаалсан байх	Эрдмийн зэргийн диплом
3	Өрхийн эмч нь тэргүүлэх зэрэг хамгаалснаас хойш нэгдүгээр зохиогчоор 5-аас доошгүй, бусад мэргэжилтэнтэй хамтран 8-аас доошгүй өгүүлэл, илтгэл, эрдэм шинжилгээ, судалгааны ажил хэлэлцүүлэн, хэвлэн нийтлүүлсэн байх,	Мэргэжлийн сэтгүүлд илтгэлийн хураангуйг нийтлүүлсэн баримт
4	Өрхийн эмч нь тэргүүлэх зэрэг хамгаалснаас хойш 8-аас доошгүй эмнэлгийн мэргэжилтэнг мэргэшүүлэх сургалтаар дагалдуулан сургаж, дадлагажуулсан байх эсвэл сургагч багшаар ажилласан байх	Сургах, дадлагажуулах удирдамж эсвэл журам, дадлагажигч эмчийн гэрчилгээ болон тайлан хамгаалалт
5	Өрхийн эмч нь тэргүүлэх зэрэг хамгаалснаас хойш мэргэжлийн ном товхимол, гарын авлага, CD, DVD аль нэгийг гарган байгууллагын ололт, амжилтанд бүртгүүлсэн байх,	Гарын авлага, ном товхимол, CD, DVD Сайн туршлагын батламж, эсвэл дээд байгууллагын Чанарын алба баталгаажуулсан байх
6	Өрхийн эмч нь тэргүүлэх зэрэг хамгаалснаас хойш Олон улсын, Улсын, орон нутгийн чанартай төсөл, хөтөлбөр, судалгааны ажилд судлаач, гүйцэтгэгчээр оролцсон байх,	Төсөл, хөтөлбөр, судалгааны тайлан, баримт
7	Өрхийн эмч нь тэргүүлэх зэрэг хамгаалснаас хойш тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах сайн туршлагыг нэвтрүүлсэн байх	Сайн туршлагын батламж, эсвэл дээд байгууллагын Чанарын алба баталгаажуулсан байх
8	Өрхийн эмч нь тэргүүлэх зэрэг хамгаалснаас хойш орон нутаг болон бүсийн хэмжээнд сургалт, зөвлөгөөнд асуудал дэвшүүлсэн илтгэл тавьж оролцсон байх,	Сургалт, зөвлөгөөн зохион байгуулсан удирдамж хөтөлбөр, оролцсон баримт, илтгэл
9	Өрхийн эмч нь ажиллах хугацааны сүүлийн 5 жилийн үндсэн ажлын үзүүлэлт 1. Хүн амын тоо 2 .Нийт үзлэг 3. Нийт үзлэгт эзлэх гэрийн эргэлт 30% байх 4. УСҮ хувь 10%-иас дээш байх 5. Хяналтын хувь 50%-иас дээш байх 6. Дархлаажуулалтын хамралтын хувь 7. Жирэмсний эрт хяналтын хувь 90%-иас дээш 9. Эхийн эндэгдэл	Тухайн байгууллагын хэрэглэж буй программаас татаж авна.

	10.0-5 насны хүүхдийн хяналтын хувь, эндэгдэл 11.Халдварт бус өвчний хяналтын хувь, - Зүрх судасны өвчний хяналт - Артерийн гипертензи өвчний хяналт - Чихрийн шижин өвчний эрт илрүүлсэн байдал - Хорт хавдар өвчнийг эрт илрүүлсэн байдал - Хоол боловсруулах өвчний хяналт 12. Нийт нас баралтын хувь	
10	Гадаад хэлний мэдлэг	Хэлний түвшин тогтоох шалгалт өгсөн байх